

ХҮНЭЭР ХҮН ХИЙХ МОНГОЛ АРГА УХААНЫ ТОВЧ ТАЙЛБАР. .

Г. Лхаахүү, хүндэт профессор, МУБИС

Аннотация: Каждая нация имеет свою уникальную культуру, которая передается из поколения в поколение и остаётся как ни с чем несравнимая ценность народа.

У монголов огромное богатство этих ценностей. Особое место среди них занимает культура слова. Мы имеем ввиду пословицы, поговорки, фразеологизмы. Эта ценность имеет своё специальное назначение. Они учат делать из человека человека, помогают познакомиться монгольскую традицию, обычаи, а также способствуют формированию чувства распознавания окружающего мира.

Пословица “Хүн ахтай, дээл захтай” означает, что любой человек может иметь брата, любая одежда имеет воротник. Это буквальный и прямой смысл данной пословицы в понимании европейцев и американцев. Для нас же - монголов, в этих словах кроется целая наука о взаимоотношениях людей, братьев. Формирование личности, мысли воспитания, уважения человека - вот основные нравоучения этой пословицы. Данная статья имеет цель научить молодёжь распознаванию ценностей словесной культуры монгольского языка. Скоро выйдет книга “Ухаарлын учгийг татахуй онч үгсийн тайлбар оршивай ” как продолжение данной темы.

Түлхүүр үг: Үнэт зүйл, үндэстэн, үгийн урлаг, онч мэргэн үгс, хүнээр хүн хийх, ширгэшгүй ундарга, учирзүйн холбоо, үгийн охь уламжлал

Монгол түмний оюуны соёлын гайхамшигийн нэг нь үгийн урлаг. Үгээр амьдралын чанар, утга агуулга, учир шалтгааныг маш товч, тодорхой оновчтойгоор илэрхийлж хэлдэг нь бидний алхам тутамд мэдэгдэж байдаг. Энэхүү гайхамшигт үгийн урыг улам баяжуулан үнэ цэнийг өндөрт өргөж, ойлгож, авч явах нь хойч үеийнхний маань үүрэг билээ. Зүйр цэцэн үгс, сургаал, онч мэргэн үгүүд нь биеэ даасан эхийн дайтай, (эх сэдэв) утга гүн, агуулга өргөн, жинхэнэ шигшмэл эрдэнэ юм. Тиймээс орчин үеийн даяаршлалын үед олон хэлийг зэрэгцүүлэн сурч ахуй нөхцөлд монгол түмнийхээ оюуны сан, үгсийн охь болсон энэ их өвөө бүр л ухан хөөж, учир зүйн нарийн холбоо авцалдааг ойлгоход хүчин чармайлт гаргах нь чухал байна.

Өнөөгийн суралцахуйн явц ч үүнийг шаардаж байгаа нь ажиглагдсаар, үгүйлэгдсээр... ЕБС-ийн сурагчдаас зүйр цэцэн үг сургаал үгсийг асуухад мэдлэг чадвар болгож эзэмшсэн нь бага, нэлээд бодож хоёр нэгэн үг хэлж байвч утга агуулгыг тайлбарлахдаа хомс байна.

Зүйр цэцэн үг, сургаал, онч мэргэн үгсээ мэдэж, утга санааг ойлгон, амьдрал ахуй, яриа бичигтээ хэрэглэж заншваас тэнгэрээс од шүүрсэнтэй л адил гэмээр...

Ард түмнийхээ бүтээсэн хэв маягаар нь ахуйтайгаа яаж холбогдож байгаа учир шалтгааныг ойлгох нь юу юунаас илүү. Зүйр цэцэн үгийнхээ учрыг мэдэхгүй, утга санааг алдагдуулж, орчуулгын үг хэллэгтэй хольж будилалгүй зөв авч явах нь зүйтэй санагдана. Үлгэрлэвэл: Эрт босвол нэгийг үзнэ, Орой унтвал нэгийг дуулна (сонсоно). Энэ үг нь нүүдэлчин монголын ахуйтай яв тав зохицсон үг. Гэтэл телевизийн зарим нэвтрүүлгээр Эрт босвол нэгийг дуулна гэх мэт ярьж байх жишээтэй. Энд учирзүйн алдаа гаргаж хүүхэд залууст буруу ойлголт өгч мэднэ. Энэчлэн алдаа гарган, монголоор сэтгэхгүй, ахуй амьдралаас нь салгаж, өнгөн талаас харах бус агуулга уялдаа холбоог нь сайтар мэдэж, судалж хэрэглэх нь зүйтэй гэж ойлгоном. Ийнхүү ухаарал, танин мэдүүлэх, гүн утга шингэсэн, үгсээ хойч үедээ учирзүйн холбоо уялдаанд нь эзэмшүүлэх бодол өвөрлөн явдгаа илэрхийлэн, **хэрэглээ** талыг голлон эл өгүүллийг бичиж байна. Энэ үүднээс зүйр цэцэн, онч үгсээ утгаар нь дараах байдлаар бүлэглэж, бүлэг тус бүрд цөөн үгийг тайлбарлав.

1. Эрдэм мэдлэг ертөнцийн баялаг
2. Хөдөлмөр бол амьдрал, хөгжлийн эх сурвалж
3. Хүн хийгээд хүмүүсийн харилцан хамаарал
4. Хүн байхын учир

1.1. Эрдмийг хичээлээр, эрлийг сургаар...

Хүмүүний зүтгэл, хичээнгүй чанар бол аливааг сурч мэдэх үндсийн үндэс, эх суурь нь болдог. Хэн их ажиллана, хичээллэнэ уншина тэр хүссэндээ хүрнэ. Өөрт байхгүйг олж мэдэхийг хүсвэл:

- Номоос асуу.
- Өөрөө бод сэтгэ, боловсруул.
- Олноос сур, мэдээлэл олж, мэдлэг болго.

Олон түмэн оломгүй далай гэсэн сайхан үг бий. Энэ мэтээр нэг зүйр цэцэн үгийг хэлэхэд нөгөө нь утга санааг нь дэлгэрүүлэн ундарч байдаг увидастай. Монгол ахуйтайгаа нягт холбоотой байдаг тул юу гэсэн санаа вэ? гэж учир шалтгааныг олж, эргэцүүлэн тунгаан бодох учиртай байна. Монгол хүн алдсан малаа олоход сурагласаар хамгийн чухал мэдээг олж авдаг. Мэдээллийн энэ чухал аргыг эрдэм сурахтай зүйрлэсэн нь эрэх, хайх, зүтгэл хичээнгүйн дүнд алив ажил бүтэж хэрэгждэгийг ойлгуулжээ.

1.2. Цэцэн үг цээжинд, цэцэг навч ууланд

Эрдэм мэдлэгт зүтгэснээрээ олон түмэнд ач тусыг түгээж байхын зэрэгцээ өөрөө од мэт гялалзан улам өнгө орон хэлэх үг нь цэгцэрч ухаан нь задарна. Ухаарлын энэ үгс тархинд боловсрогдоод цэцэг лугаа адил хүнийг сэргээж, баясган хөгжүүлж байдаг. Хүн байгал шүтэлцэн цэцэн мэргэн үгсийг бүтээж байдгийн нэгэн жишээ энэ амой. Монголын ард түмний үгийн тунгаамал болсон энэ мэт үгсээ мэдэж, сурч, амьдрал ахуйдаа санааг нь тусгах, яриа бичгийн соёлдоо хэрэглэж сурах нь хэлний дархлаа бий болгож, монгол ахуй, зан заншлаа ойлгоход ач холбогдолтой төдийгүй та монгол хүн гэдэг тань танигдах юм. Монгол хүн эрдэм боловсролтой, цэцэн цэлмэг яриатай хүнийг “чээжтэй” гэж үнэлдэг

1.3. Өмсөж зүүх нь гайхамшиг ч, үг хэл нь зүгшрээгүй

Эрдэм соёл бол хүн төрөлхтний нийгмийн хөгжлийн үе цаг бүрд янз янзын хэлбэр жаягаар хөгжиж, цэцэглэдэг жамтай. Соёлыг гадаад дотоод гэж үзэж болно. Дотоод соёлд, сэтгэлийн соёл, ухааны соёл юу юунаас ч үнэтэй. Тогос шиг гоё атлаа нэг өгүүлбэр эвлүүлэн хэлж мэдэхгүй, үр хүүхэд, залууст ухаарах хоёр үг хэлэх чадваргүй бол хэчнээн гоё байгаад хэрэггүй. Гаднаа гяланцаг, дотроо паланцаг гэгч болном. Энэ мэтээр эрдэмжиж боловсрохын ухааныг сургасан нь арвин. Орчин цагт, хэн нэгэндээ ганц болов баясал төрөхөөр, ухаарахаар үг хэлэх нь үнэт эрдэнэ олсон мэт. Үгийн үнэ цэнэ, ид шидийг хүүхэд залуус, мэдээлэл дамжуулдаг хүмүүс маш зөв ойлгож, хэрэгжүүлж сурахыг сургамжилсан үг.

2.1. Ажил хийж хүн болдог, ар давж хүлэг болдог

Хүүхдийн нас биед тохирсон ажлыгбагаас нь хийлгэж сургах нь хүн болохын эхлэл. Ажил

хөдөлмөрийн дунд хүн болж, ухаажин, сурах, ажиллах хүсэл сонирхол, сэдэл тэмүүлэл бий болно. Ажил хийснээрээ амьдрах арга ухаанд суралцана. Хэн их хөдөлмөрлөнө, тэр од шиг гялалзаж, аз жаргалтай хангалуун амьдарна. Ажил хийсэн хүн, хүссэн бүхэндээ хүрч чадна. Монгол хүн ажил амьдралынхаа хиймор, хүчтэй, цоглог бүхнийг морьтойгоо зүйрлэдэг. Тиймдээ ч хүн болох явцыг хүлэг болох үйлтэй нэгэн санаанд нэгтгэн хэлж сургамжилжээ.

2.2. Санаж явбал бүтнэ, сажилж явбал хүрнэ

Ямарч зүйлийг урдаас бодож төлөвлө. Ер алив бүтээл, эхлээд тархинд боловсрогдон тунгаагддаг. Бодож төлөвлөсөн юм түргэн ч, удаан ч заавал бүтнэ. Сэтгэлдээ нэгийг бодож, зорилго тавь. Хэзээ нэгэн цагт биелэлээ олж, амжилт авч ирнэ гэсэн санаа. Яарч сандарснаас алдаа гарах нь их. Энэхүү зүйр үг, монгол ахуйтайгаа нягт холбогдож байна. Унаа малаа хайрлах давхар санаа бас бий. Мориныхоо хар хурдаар давхиад байвал зорьсондоо хүрэлгүй унаа цуцна гэсэн санаа нь алив юманд сэтгэлийн хөөрлөөр бүү ханд гэсэн дотоод үзэл. Сажилж яв гэдэг нь хүн зүгээр суулгүй, хөдөлж, хөдөлмөрлөн, зогсолтгүй ажиллахыг сануулсан сургамж. Энэ санаа бол байнга гэлдэрч яв гэсэн санаа бус. Хүн байнгын хөдөлгөөнд бай гэсэн утга юм.

2.3. Ажилд дадлага, ачаанд татлага хэрэгтэй

Ямарч ажлыг хийхэд дадлага хэрэгтэйг хэн бүхэн мэднэ. Гэхдээ дадлага гэдэг нэгэн өдөр гэнт бий болдог зүйл биш! Олон удаагийн давтамжаар төлөвшин тогтдог. Дадлагатай болохын тулд багаас оролдох, хийх аргаа зөв тодорхойлох үйл явц чухал. Арга бол хийж буй эд юмс, хүний оюун ухааны харилцан шүтэлцлээс урган гарч хөгжинө. Аргаар дамжин хүний дотоод нөөцийн чадавх илэрнэ. Тэмээ хөсөг, машин тэргэнд ачааг ямарч бэхэлгээ татлагагүйгээр сул тавьчаад хол замд явъя гээд бодъё. Ямар байх вэ. Тэгэхээр дадлага, татлага аль аль нь амьдралд чухал болохыг илэрхийлсэн зүйрлэл байна даа. Ямарч ажлыг хийхэд хэрэглэгдэхүүнээ урдаас бодож, бэлтгэхийг ухааруулсан санаа.

1.1. Хүний нүнжиг сэтгэлээр, хүнсний нүнжиг чанараар

Энэ зүйр цэцэн үгээр хүний сэтгэлийн илэрхийлэл, чанарын тухай хэлжээ. Хүн хоол ундгүйгээр удаан амьдрахгүй, тэр мөртөө амт

чанартай хоолонд дурлана. Амьдралыг тэтгэгч хоолтой хүний нүнжгийг зүйрлэсэн нь айхтар гүнзгий холбоо байна гэж ойлгоно. Хүний нүнжиг гэдэг чанартай, жудагтай гэсэн утгыг агуулдаг. Сэтгэл зөвтэй, сайхан санаа гаргаж, нэгэндээ сэтгэлийн дэм өгч юухнаар ч сэтгэлийнх нь галыг асааж байх нь нүнжигтэй сайн хүний л шинж байдаг. Үүнээс гадна эд, эдлэлийн нүнжиг гэж буй. Эцэст нь хэлэхэд энэ зүйр үг бол чанарын тухай л сургаал.

1.2. Зан сайт айлд хүн бүр цуглана, замаг сайт усанд шувуу болгон цуглана

Өнөөгийн бидний ойлголтоор нийгэмшсэн, нийтлэг, хүнлэг хамтач үзэлтэй байхыг сургасан монгол ухаан. Монгол хүн орсон гарсанд ундтай, устай, хойгуураа гарсныг хооллож, урдуураа гарсныг ундалдаг заншилтай. Энэ ёсыг гэрийн эзэгтэйтэй холбон үздэг нь эмэгтэйчүүд хийгээд өрх айлыг үнэлсэн монгол үнэлгээ. Нөхрийн нэрээр орж, эзэгтэйн нэрээр гардаг гэдэг. Ааш зан төвшин айлд ахан дүүс төдийгүй, найз нөхөд нь ч зочлох дуртай. Ийм сайхан монгол заншлаа алдаж орхиж яавч болохгүй. Нуурандаа чуулсан шувуудыг харахад хэн хүний нүд, сэтгэл баясаж, сэтгэлийн амар амгаланг эдэлдэг шүүдээ. Байгалийн ийм сайхныг хүний сайнтай харьцуулсан маш сайхан ухаарал таашаалыг төрүүлэхээр зүйрлэл юм.

1.3. Олны хүч эвэндээ, олсны хүч эрчиндээ

Алив зүйлийг бүтээхэд арга чухал. Аргаа олсон бол хамт ажиллагсад, бие биеэ ойлгох, дэмжих явдал. Эвтэй найртай байх нь амжилтын үндэс. Эв муутай хоорондоо зохицолгүй бол ямар сайхан ажил байлаа ч бүтэхгүй. Эрдэмгүй хүн таг, эегүй хүн яг гэдэг. Яг гэдэг нь мухардмал гэсэн санаагаар энд өгүүлэгдэж байна. Олны олон таван цэн гэх мэтээр олон түмэн юутай ч зүйрлэшгүй хүч. Тэрхүү хүч чадал нь эв нэгдэлдээ байдаг гэсэн сургамж юм. Ингэж хүн хүндээ харилцан хамаарч урагшлахын үндэс бий болно.

1.4. Үүд муутын хоймор бүү суу, удам муутын хүүхнийг бүү ав

Дээрх зүйр үг нь тус бүрийн утгаараа бус “Үүд муут” гэсэн нийлэмж утгаараа удам судар, тухайн амьдралын хэв ёсыг шүүмжлэн хэлж сануулсан утгатай. Уг айлын амьдралаа удирдах ухаан, зан заншил, ааш авир, үйл явдлыг дүгнэн, үр хүүхдэдээ ойлгуулж, сануулан, хань ижлээ сонгохдоо яаж хандах хандлага, үзэл бодлыг

сургамжилж, ухааруулсан үг. Удмыг харж ханиа сонгохын гол учиг нь хүний нүнжиг, хүнлэг чанарыг ихэд анхаарна. Сайн хань олж амьдарна гэдэг ямарч үнэтэй алмаз эрдэнэтэй зүйрлэх аргагүй үнэт зүйл.

4.1. Үнэн үг хатууч, хэтийн амьдралд тустай

Өөрийн бурууг мэддэггүй, санаснаараа зүтгэдэг хүн өрөөлийн үгийг сонсох нь муу байдаг. Энэ сайн чанар биш. “Өөрийгөө хүний нүдээр харж бай” гэдэг чухал сургаал бий. Энэ бол хүн байхын сонгодог монгол ухаан гэж би ойлгодог. Хэтэрхий ”Би”-г шүтвэл буруу зүйлээ ч зөв хэмээн сэтгэж, өөрөө ч, бусдыг ч төөрөгдөлд оруулж, засрашгүй байдалд хүрч мэднэ. Яг үнэнийг хэлэхэд хатуу үг мэт бодогдовч анхааран хүлээн ав. Халдагчийн үг хатуу ч сургаалд тустай гэдэг. Монгол цэцэн мэргэн үгс өнөө маргаашийг аргацаасан бус маш холын ухааралын учгийг татдагаараа гайхамшигтай. Энэ зүйр үг бол бусдыг сонсож сурах, тэвчээр, соёлын их үндэс байна.

1.2. Сайн нэрийг хүсээд олдохгүй, муу нэрийг хусаад арилахгүй

Тэнгэрийн муухай арилдаг хүний муу арилдаггүй гэдгийн нэгэн хувилбар. Сайн нэрийг зөв сэтгэл, зөв үйл хийж бүтээснээр олно. Хүний мөс чанар бол сайн хүнийг илэрхийлэх чухал үзүүлэлт. Амьдралынхаа алхам тутамд зөв эерэг хандлагатай явахад сайн нь хөгжиж, муу үйл үл ирнэ. Тиймээс амьдралдаа хичээж яв. Муугаас хол бай гэдгийг сургамжилжээ. Сайн явах санааных гэдэг. Дотоод сэтгэлээ цэвэр ариун байлгаж чадвал бүх юм сайхан байх болно доо.

1.3. Цадахад цагаан хурганы сүүл хатуу, өлсөхөд өлөн бугын эвэр зөөлөн

Монгол харьцууллын ухааныг сэтгэлийн угаас биширнэм. Махны хамгийн зөөлөн сүүлийг, ясны төрөл эвэртэй шинж чанараар харьцуулна гэдэг үнэхээр гайхалтай. Өнөөдөр мөр бүтэн, гэдэс цатгалан, амьдрал сайн сайхан байна гэж цамаархаж болдоггүй, Хүн долоо дордож, найм сэхдэг гэдэг. Зөөлөн цагаан сүүлээ хатуу мэт сэтгэж, амьдралын олон өнгийг ухаарахгүй бол тэнэгийн шинж. Ийнхүү ертөнцийн олон өнгийг мэдэрч амьдар. Юм нэгээр дуусдаггүй гэсэн сургамжит санаа.

Энэ мэт зүйр цэцэн, онч мэргэн, сургаал үгсээ бидний өвөг дээдсээс олон зуун мянгаад амаар дамжуулан өнөө үе хүртэл уламжлан

иржээ. Онцгой сонсголонтой, учирзүйн нарийн хамааралтай, сургаал үгсээрээ үр хүүхдээ хүн болгож, амьдралд хөлийг олуулж байсан монгол ухааныг судлаад ч, бишрээд ч баршгүй. Дундарч дуусашгүй, энэ их өвийг ахуй амьдралдаа хэрэглэж, баяжуулан түгээх нь бид бүхний үүрэг билээ.

ДҮГНЭЛТ

Эрдэмтэн судлаачид аман зохиолын энэ төрөл зүйлийг хүн, байгал, нийгмийн уялдаа холбооны нөхцөлдсөн учир шалтгаан, хөгжлийн гүн ухаан, үгийн урлаг, түүх уран сайхны талд тулгуурлан тайлбарласан нь байдаг. Бид хүмүүнлэг ардчилсан нийгэмд “**хүнээр хүн хийх**” монгол ухааны зөв **төлөвшил бий болгоход** зүйр цэцэн, онч үгсэд яаж хэлсэн, эндээс **танин мэдүүлэх** санаа нь юу болох, ямар **ухаарал** олж авах вэ гэдгийг тайлбарлахыг хичээлээ. Эл өгүүлэлд та бүхэн анхаарал хандуулснаар:

- Шинэ нийгмийг цогцлоох тулгууруудын нэг нь хүн хоорондын итгэлцэл, хүндэтгэлд суурилсан харилцаа мөн гэдэгтэй санаа бодлоо хуваалцах;
- Хүн байгаль, тэдгээрийн харилцан нөлөөлөл, байгалиа гэх шүтэн бишрэхүйн ухаан болоход санал нэгдэх;
- Монгол хэлний онч мэргэн үгсийн онцлог, тэдгээрийн утга тайллыг ухааран, асуудлыг шийдэхдээ санаж явахыг хичээх;
- Тэрчлэн Монголчуудын үгэн сургаалаараа хүн төлөвшүүлж ирсэн арга ухаанаас бага ч болов танилцах болов уу.
-

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Баттогтох, Д.(2003). *100 хэлц, дасгал сорилго*. Улаанбаатар
- Дашдорж, Ж., Ринчэнсамбуу, Д. (2008). *Монгол ардын зүйр цэцэн үг*. Улаанбаатар
- Жадамба, Б., Эрдэнэчимэг, Л. (2011). Монгол аман зохиолын зарим төрөл зүйлдэх тулхтай (тогтвортой) хөгжихүйц болверолын үзэл санаа. *Лавай*. Улаанбаатар
- Нямдаваа, Д. (2011). *Уншихгүй байж болохгүй ном*. Улаанбаатар
- Цэрэнсодном, Д. (2011). *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*. Улаанбаатар